

Түүх 2 : Христийн төрөлт

Библийн эшлэл
[Исаиа 7:14]

Үзэгтэн! Нэгэн онгон бүсгүй хөл хүндтэй болж, Хүү төрүүлж,
Түүнийгээ “Иммануел” гэж нэрлэнэ. (Исаиа 7:14)
Түүнийг Иммануел (орчуулбал “Бурхан бидэнтэй хамт”) гэж тэд нэрлэнэ гэсэн юм. (Матай 1:23)

Эрт урьдын цагт Израилийн Назар гэгдэх хотод нэгэн Мариа гэх үзэсгэлэнтэй бүсгүй амьдран суудаг байжээ.

Харин Мариа, сайхан сэтгэлтэй мужаанчин Иосефтэй сүй тавьсан байлаа.

Тэр үед Бурханд итгэдэггүй Херод, Израилийг хаанчилж байсан бөгөөд Израиль ард түмэн Бурханаас холдож маш их хүнд хэцүү амьдралыг туулж байв. Нэгэн шөнө Мариаг унтаж байх үед нь гэнэт Габриель тэнгэр элч гарч ирэв.

“Мариа, бүү ай. Чи Бурханы тааллыг олжээ. Чи Ариун Сүнсээр хэвлийдээ үртэй болж Хүү төрүүлнэ. Түүнийг чи Есүс гэж нэрлэх болно. Эзэн Бурхан Түүнд өвөг Давидынх нь хаан ширээг өгөх болно.” гэв. Үүнийг сонссон Мариа ингэж хэлэв.

“Би хараахан хуримаа хийгээгүй байхад яаж хүүхэд төрүүлэх вэ дээ?” Габриель тэнгэр элч дахин айлдав.

“Хүний хүү бус Бурханы хүчээр Хүү төрөх болно. Бяцхан Хүү Бурханы Хүү гэж дуудагдах болно.”

Тухайн үед гэрлээгүй эмэгтэй хүүхэдтэй болвол чулуугаар цохиулж үхэх аюултай байсан учраас Мариагийн хувьд их аймшигтай зүйл тохиолдож ч магадгүй байлаа. Бас гэрлэх гэж байсан Иосефт хаягдах аюул тулгараад байлаа.

Гэсэн хэдий ч Мариа, нөхөрт гараагүй байгаа хэрнээ Хүүтэй болох болно гэсэн Бурханы үгэнд дуулгавартай байж бүр чин сэтгэлээсээ Түүнд талархлын магтаалыг өргөж байв.

Нээх их хугацаа өнгөрөөгүй байхад тэнгэр элчийн хэлсэнчлэн Мариа хэвлийдээ үртэй болов.

Мариатай сүй тавьсан залуу Иосеф нь сайхан сэтгэлтэй төдийгүй зөвт хүн байлаа.

Гэвч тэрээр, Мариа хэвлийдээ Хүү тээсэн байгаа гэх айхтар мэдээг хүлээж авахад хэцүү байлаа.

Иосеф, Мариатай хурим хийж чадахгүй гэсэн шийдвэрт хүрч үүнийгээ Мариад хэлхээр сэтгэл шулуудсан байв.

Гэтэл нэгэн өдөр Иосефын зүүдэнд тэнгэр элч гарч ирэв.

“Давидын хүү Иосеф оо, Мариаг эхнэрээ болгохоос бүү эмээгтүн.

Учир нь түүнд олдрод байгаа нь Ариун Сүнснийх юм. Тэрээр нэгэн Хүү төрүүлж, Тэр нь ард түмнээ нүглээс нь аврах



тул чи Түүний нэрийг Есүс хэмээн нэрлэ гэв.”

Тэнгэр элчийн үгийг сонссон Иосеф амлалт өгч үүнийхээ дагуу Мариатай гэрлэв.

Хэдэн сарын дараа, Иосеф төрөх дөхсөн Мариагаа дагуулаад өөрийн төрсөн нутаг болох Бетелхем уруу явах шаардлагатай болов.

Учир нь бүх хүмүүсийг өөрсдийн төрсөн нутагруугаа буцацгаан хүн амын тооллогонд орцгоохыг шаардсан тушаалыг буулгасан байв.

Иосеф Мариа хоёр явсаар бүрий болов. Гэтэл тэдэнд хоноглох газар олдохгүй байв. Учир нь Бетелхемд хүн амын тооллогонд орхоор ирсэн хүмүүсээр дүүрсэн байлаа.


Хоноглох газраа хайж олж чадаагүй Иосеф, Мариа хоёр арайхийн малын саравчинд толгой хорогдов.

Тэр шөнө Мариа Хүү Есүсийг төрүүлэв. Ард түмнээ гэм нүглээс нь аврах Бурханы Хүү Есүс Христ билээ.

● Дараах библийн эшлэлийг дагаж бичээд цээжлээрэй.. (Матай 1:23)

Түүнийг Иммануел гэж нэрлэнэ.





Жишээ зураг



Материалууд :

Хайч, Өнгийн харандаа, Цавуу

Бүтээлч байцгаая 2. Өнөөдөр юу сурснаа сайн бодонгоо өнгөөр ялгаж будаарай.

